

ФЕДЕРАЛЬНОЕ ГОСУДАРСТВЕННОЕ
БЮДЖЕТНОЕ УЧРЕЖДЕНИЕ НАУКИ
ИНСТИТУТ МОНГОЛОВЕДЕНИЯ, БУДДОЛОГИИ
И ТИБЕТОЛОГИИ СИБИРСКОГО ОТДЕЛЕНИЯ
РОССИЙСКОЙ АКАДЕМИИ НАУК

**КУЛЬТУРА
ЦЕНТРАЛЬНОЙ
АЗИИ**

*письменные
источники*

Вып. 12

Улан-Удэ
2019

УДК 930
ББК 63.2+86.39(5А/Я)
К 906

Редакционная коллегия:

д-р ист. наук, проф. *Ц. П. Ванчикова* (отв. ред.),
д-р ист. наук *С. В. Бураева*, канд. филол. наук *Д. В. Дашибалова*,
канд. ист. наук *М. В. Аюшеева* (секретарь)

Рецензенты:

д-р культурологии, проф. *М. И. Гомбоева*
д-р. ист. наук *Л. В. Курас*
канд. филол. наук, доц. *О. Д. Тугулова*

К 906 **Культура Центральной Азии: письменные источники. Вып. 12.** – Улан-Удэ, 2019. – 222 с.

ISSN 2304-1838

Предлагаемый вниманию читателей очередной номер серии «Культура Центральной Азии: письменные источники» состоит из трех крупных блоков. В первом – публикуются статьи, анализирующие отдельные вопросы истории религий и буддийской философии, представлен перевод 16–25 глав «Ратна-гуна-самчаягатха». Второй блок посвящен изучению цифровых технологий в гуманитарных исследованиях; в третий блок включены статьи, связанные с изучением письменных источников и архивных документов.

Представляет интерес для специалистов и широкого круга читателей, интересующихся вопросами истории и культуры народов Центральной Азии.

ISSN 2304-1838

© ИМБТ СО РАН, 2019
© Коллектив авторов, 2019

Дэмчигмаа О.

Уул УСАА ДЭЭДЛЭН ШҮТЭХ МОНГОЛ ЁС ХИЙГЭЭД САН ТАХИЛГЫН СУДАР

Монголчуудын уул усаа дээдлэн тахих зан үйл нэн эртний уламжлалтай бөгөөд эрт үедээ бөөгийн шүтлэг байгаад хожмоо бурханы шашны нөлөөгөөр өргөжин хөгжжээ.

Монгол орны өргөн уудам нутагт 800 орчим уул усыг тахиж ирсний олонх нь сан тахилгын судартай байв. Гэвч үүнээс олон ч байсан байж магадгүй. Хөдөө орон нутгийн музейн сан хөмрөг ба хувь хүмүүсийн гар дээрээс олдсоор байгаа билээ.

Сан тахилгын судруудад тухайн уул усыг шинжин, эзэд савдагийг орчин нөхцөл, ахуй байдалд нь тохируулан сэтгэлдээ ургуулан төсөөлж, уран сайхнаар сэтгэн дүрслэхийн сацуу монгол ахуйг тод тусгаснаараа ихээхэн онцлогтой. Тухайлбал, говь нутагт голдуу тэмээ хөлөглөсөн дүрээр, хангай нутагт сарлаг хөлөглөсөн гэх мэт. Түүнчлэн монгол дээл өмссөн, хурганы уут өлгөсөн зэргээр дүрсэлсэн нь ахуйн буюу иргэний байдалд идээшүүлсэн хэрэг бөгөөд ард олны таалалд илүү нийцэн, сэтгэлд нь хоногшиход тун дөхөм болсон гэлтэй.

Ийнхүү уул усаа тахин шүтэхтэй холбоотойгоор хорио цээрийн ёс бий болж, эдүгээ ч гүн бат оршсоор байна.

Түлхүүр үг: уул усаа дээдлэн тахих зан үйл, обоо тахих, монгол, сан тахилгын судар.

ПОЧИТАНИЕ ХОЗЯЕВ МЕСТНОСТЕЙ У МОНГОЛОВ И *СУТРЫ ВОСКУРЕНИЙ*

Традиция почитания природы у монгольских народов имеет давние корни в шаманской практике. С распространением буддизма данная традиция была инкорпорирована в буддийскую практику. В Монголии почитались более 800 гор и водных объектов, и большая часть из них имела специальные тексты для почитания – саны-воскурения, к сожалению, не все сохранились до наших дней. Много текстов сосредоточено в музейных коллекциях, библиотеках, частных собраниях. В текстах почитания, в описаниях хозяев гор и водоемов, отражены особенности хозяйственного уклада и традиционной культуры монголов. Например, в текстах, распространенных в гобийских местностях они чаще изображаются верхом на верблюдах, а в текстах, связанных с горными или лесными местностями – на яках. Также они изображают-

ся в монгольской одежде – дээл, с мешками для новорожденных ягнят, отражающих разнообразие не только хозяйственного, но и общественного уклада, соответствовавшие их мировоззрению. Подобные образы хозяев местностей, запреты, связанные с их почитанием, подчеркивают тесную связь текстов почитания с народным бытом, с созданием экологических традиций по сохранению окружающей природы, сохраняемых вплоть до наших дней.

Ключевые слова: почитание хозяев местности, культ обо, монголы, тексты воскурений.

Demchigmaa O.

WORSHIPING OF THE LORDS OF SACRED PLACES IN MONGOLIA AND THE INCENSE OFFERING SUTRAS

The tradition of nature worshiping among the Mongolian peoples has long roots in shamanistic practice. With the spread of Buddhism, this tradition was incorporated into Buddhist practice. In Mongolia, more than 800 sacred localities were revered, and most of them had special texts for worship – *san*-incense offering, unfortunately, not all have survived up to this day. Many texts are concentrated in museum collections, libraries, and private collections. In these texts the descriptions of the lords of mountains and ponds reflect the features of economic structure and traditional culture of the Mongols. For example, in texts distributed in desert areas, they are more often depicted riding on camels, on mountainous or forest areas - on yaks. The lords of the sacred places are also portrayed in Mongolian clothes - *deel*, with bags for newborn lambs. Such images of the owners not only emphasize close connection of the texts of worship with the traditional life, but also they are closely connected with establishing ethnic ecological traditions aimed at conservation and preservation of surrounding nature.

Keywords: worshiping of the lords of mountains and water sources, cult of obo, Mongols, texts of incense offering.

А. Уул усны тахил шүтлэгийн уг сурвалж

Монголчуудын уул овоогоо дээдлэн тахих зан үйл нь газар усаа эрхэмлэн хүндэтгэх нэн эртний сэтгэлгээний илрэл юм. Тэнгэр хангай, уулс ус, бэлчээр нутагтаа шүтэж, нүүдэллэн аж төрдөг монгол түмний хувьд энэ бол эрхэм нандин уламжлал бөгөөд бүр Хүннүгийн үеэс эхтэй ажээ. Уул даваа бүхнийг эзэн

савдагтай, ус мөрөн бүхнийг лустай хэмээн бишрэн сүсэлж, тахил мөргөл үйлдсээр ирсэн зан үйлийн ул мөр, түүх бичиг хийгээд аман яруу найрагт хадгалагдаж байдаг. 13 дугаар зууны үед эзэн Чингис хаан Бурхан Халдун уулнаа есөнтөө сөгдөн өчил өчиж, цацал өргөж үүрд тахиж байхыг андгайлсан [Rachewiltz, 1972: 40] тухай "МНТ"-д тодорхой буй.

Уул ус тахиx зан үйл бөө мөргөлөөс үүдэлтэй. Мөнх тэнгэр бол монголчуудын эртний шүтлэг бөгөөд аливаа үйл гагцхүү тэнгэрийн тааллаар болдог гэдэгт итгэлтэй байсан нь түүх дурсгал, бөө мөргөлөөс харахад тодорхой. Өөрөөр хэлбэл, тэнгэр бол нүүдэлчин монголчуудын тухайд бурхан нь байв. Тиймээс тэнгэртэйгээ ойр байж, хүсэл зорилгоо хүргэхийн тул орчин тойрныхоо хамгийн өндөр газар овоо босгон, тахилын орон болгож байжээ. Түүнчлэн өвс ургамал, ус бэлчээр элбэг дэлбэг байх нь газрын эзэн Этүгэн эхээс хамаардаг хэмээн итгэж, мал сүргээ даатган, тахин шүтсээр, эдгээр үзэл нь аажимдаа уул овоо, гол усаа тахиx зан үйл болон хувирчээ.

Газар нутаг бүрт уул овоог тахиx, билгийн тооллын тогтсон өдөртэй байх бөгөөд жилд нэг удаа тохионо. Өндөр уул давааны овоог эзэн савдагийн овоо, рашаан булаг, гол мөрний эхэнд босгосон овоог лусын овоо гэнэ. Тахилгат уул овоонуудыг их тахилгатай, дунд тахилгатай, бага тахилгатай, байнгын шүтлэгтэй гэхээс гадна олноор тахиx, өрх гэрээр тахиx, нийгмийн анги давхаргаар тахиx зэрэг ялгаатай байв. Тухайлбал, Чингэлтэй хайрханыг номч лам нар, Баянзүрх хайрханыг худалдаа наймаа эрхлэгчид, Богд хан уулыг засаг ноёд тахиж ирсэн түүхтэй [Сүхбаатар, 2001: 17]. Бурхан халдун, Богд хан уул, Отгонтэнгэр, Алтан Дарь овоо гэсэн төрийн их тахилгатай дөрвөн уул бий. Бурхан Халдун уул Чингис хааны үеэс тахилга шүтлэгтэй болсон, Богд Хан уул мөн өнө эртнээс тахилга шүтлэгтэй байсан хийгээд дэлхийн анхны дархан цаазат газар, Отгонтэнгэр уул Монгол түмний заяа буяныг дааж байдаг, арван хангалын нэг Очирваань сахиусны орших орон, Алтан Овоо

халх нутгийн хил хязгаарын харуул овоо хэмээн ихээхэн хүндэлдэг юм.

Б. Бурханы шашны нөлөө тусгал

Бөөгийн шүтлэг болох уул овоо тахих ёс нь хожим бурханы шашны ёслол, зан үйлээр өргөжин хэвшжээ. Тухайлбал, Богд уулын эзнийг гучин гурван саарал морь унасан Дүнжингарав бөгөөд умаа хумын тахилгатай гэсэн байдаг. Гучин гурван саарал морь нь бөөгийн шашнаас үүдэлтэй, Дүнжингарав ум аа хум нь шарын шашнаас гаралтай юм [Сүхбаатар, 2001: 14]. Шарын шашны нөлөөгөөр нэлээд олон уулын эзэн савдагийг догшин бурхан сахиусаар дүрслэх болсон бололтой. Богд хан уулын эзэн Дүнжингарав, Отгонтэнгэр уулын эзэн Очирваань, Архангай аймгийн Суварга хайрханы эзэн Далх, Дундговь аймгийн Бага Газарын чулууны эзэн Жамсран бурхан гэх мэт. Мөнхүү зарим уулын нэр ойролцоо дуудлагатай төвөд үгээр солигдон нэршсэн тохиолдлууд нэлээд буй.

В. Уул усны сан тахилгын судар

1. Агуулга, зэрэг дараалал:

Монголчууд найман зуу орчим уул усыг тахиж ирсний олонхи нь сан тахилгын судартай байсан [Сүхбаатар, 2001: 16], түүнээс эрдэмтэн О.Сүхбаатар гуай хоёр зуун ная орчмыг олсон байна. Монгол орны өргөн уудам нутагт үүнээс ч олон газар усыг тахиж байсан байж магад. Хөдөө орон нутгийн музейн хөмрөг болон хувь хүмүүсийн гар дээрээс эдүгээ хүртэл олдсоор байгаа билээ. Судруудын дийлэнхийг төвөд хэлээр зохиосон байхын зэрэгцээ монгол бичгийн судар ч чамгүй олноор уламжлан ирсэн юм. Сан тахилгын судруудыг үзвэл дараахи агуулгатай байна.

<i>Сэтгэл үүсгэх</i>	Эхлээд бурхан сахиусаддаа итгэл одуулан, сэтгэл үүсгэнэ.
<i>Залах</i>	Эзэд савдагийг нөхөд сэлтийн хамт урин залж, арслант сэнтий, лянхуат суудалд суулгав хэмээн

	сэтгэлдээ дүрслэн бодно.
<i>Баясгах</i>	Арц хүж зэрэг элдэв зүйлийн анхилуун үнэртэн, цэцэг зул тэргүүтнээр тахил өргөн, түүнийг сайхан үнэр хийгээд ая хөгжмөөр баясгана.
<i>Өргөл өргөх</i>	Газар залран бууж ирсэн эзэн савдаг, навдаг, шивдагт идээ цагаа, үнэт эд эрдэнэс, хоргой торго, элдэв төрлийн үр жимс, хонь ямаа, хүлэг морь, буур бух тэргүүтнээс эхлээд ан амьтан, араатан жигүүртнийг өргөхийг дурдан, заримдаа мал сэтэрлэх ёслол үйлдэнэ. Сэтэрлэх зан үйл нь тухайн малыг бурхан тэнгэр, газар усны эзэн савдагт өргөж, дархлан онголж байгаа хэрэг юм. Тахил өргөл нь үзэх, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх таван мэдрэхүйд тулгуурлан бүтсэн бөгөөд энэ нь уул, овооны эздийг амьдчилан хүншүүлж үздэгийн илрэл юм.
<i>Ариулах</i>	Элдэв үнэртэн арц хүж, цагаан зандан, агар, цагаан агь зэргийг уугиулсан утаагаар газар дэлхий, уул усны эздийг ариулна.
<i>Наманчилах</i>	Аливаа гэм алдал, нүгэл хилэнц бүхнээ тоочин дурдаж наманчилна.
<i>Залбиран даатгах</i>	Ямарваа гэм хорлол, муу муухай бүхнээс сахин хамгаалж, өвчин хижиг, дайн самуун, зуд турхан, хулгай дээрмийг амарлиулж, мал сүргийн буян хишиг, байгаль дэлхийн үр шимийг дэлгэрүүлэхийг хүсэн залбирч даатгана.
<i>Ерөөх</i>	Өлзий хутаг орших хийгээд бурханы шашин өнө удаан мандан бадрахыг ерөөнө.

Уул усны тахилгын судрыг ерөнхийдөө иймэрхүү байдлаар зохиож ирсэн бөгөөд энэ нь хүн зон аливаа хүсэл зорилгоо газар орныхоо тэнгэр, лусад өчин даатгаж байгаа санаа хэмээвээс зохилтой.

2. Эзэн савдагийн дүрслэл

16 дугаар зуунаас шарын шашин Монголд хүчтэй дэлгэрсэнтэй холбоотойгоор уул усыг тахиx, шүтэх ёсонд ч

нэлээд өөрчлөлт орсныг дурдсан. Тийнхүү нэгэнт хэвшээд байсан бөөгийн зан үйлээс шарын шашныхан монголчуудын ахуй амьдралд тохируулан өөрчлөөд, эртнээс шүтэн дээдэлж ирсэн уул усных нь эзэн савдагийг тодорхой дүрслэн, түүнд зориулсан сан тахилгын судруудыг зохиож, зан үйлийн тусгай дэг жаяг буй болгосон нь ард иргэдийн таалалд ихэд нийцэж, бат төлөвшин тогтож чаджээ.

Уул даваа, гол мөрөн, нуур ус өөрийн эзэнтэй гэсэн үзлийн үүднээс тэдгээрийг тахин баясаж, ач ивээлийг хүртэх зорилгоор уншлага, зан үйлийн ном судрыг тусгайлан зохиож, гарын авлага болгон хэрэглэсээр ирсэн тухай дээр өгүүлсэн билээ. Газар усны эзнийг *савдаг (sa bdag)*, *навдаг (gnas bdag)*, *шивдаг (gzhi bdag)*, *юлха (yul lha)* гэх зэргээр нэрлэж ирсэн нь “газрын эзэн, орны эзэн” гэсэн утгатай, төвөд гаралтай үгс юм. Монголын газар усны эзэн савдаг олон янзын дүр байдалтай хийгээд газар нутгийн өвөрмөц онцлогийг тусгасан байдаг талтай. Эзэд савдагийг хэрхэн дүрсэлсэн байдлаас заримыг өгүүлбэл:

1. Тухай тухайн газар нутгийн эзэн савдагийг өөр өөрөөр дүрслэн өгүүлдэг нь зохиогчийн үзэл бодлоос хамаарахын сацуу тэрхүү газар орны байр байдал, байгалийн тогтоцтой холбоотой байх нь олонтаа. Жишээлбэл, Сонгинохайрхан уулын сангийн судрыг Их Хүрээний нэгэн эрдэмт лам Төвөдөөс залагдсан ирсэн ламаар зохиолгохоор дуртгасанд, тэрхүү төвөд лам уулыг шинжин хараад их цэргийн ноёны дүртэй уул юм. Гэхдээ айхтар догшин аж. Хатуу үйлийг хүсэн залбирахад түргэн бүтээх шидтэй юм. Эзэн савдаг нь хөх бух унасан, араа соёо нь зөрсөн, архинд дуртай хөх өвгөн байна хэмээн таацуулан зохиосон гэдэг [Сүхбаатар, 2001: 11]. Тийм ч учраас Сонгинохайрхан ууланд архиар сэржим өргөдөг учиртай.

2. Нутаг орны ахуй онцлог туссан байна. Говирхог нутагт голдуу тэмээ хөлөглөсөн эзэн савдагийг дүрсэлдэг бол уулархаг хангай нутагт сарлаг хөлөглөснөөр дүрсэлсэн байдаг.

Тухайлбал: Дундговь аймагт орших Их Газарын чулуу хэмээх байгалийн үзэсгэлэнт уулын тахилгын сударт: “...*хар хүрэн өнгөт лагшинтай, нэг нигуур, хоёр мутартай., баруун мутартаа балт сүх, зүүн мутартаа төмөр гох барьсан, айдас хүргэм, хүрэн тэмээ хөлөглөсөн*” [Sa chen ri po'i bsangs mchod 'bul tshul mdor bsdus pa las bzhi lhun 'grub bzhugs so, 3 х.] гэж байхад Завхан, Говь-Алтай аймгийн зааг нутагт орших Хасагт хайрхан уулын сангийн сударт: “...*хөхөмдөг сарлагийн дээдийг хөлөглөсөн*” [Ha sag thu ha ri han la bsangs mchod bkra shis sman ljong zhes bya ba bzhugs s., 4 х.] хэмээсэн байх жишээтэй. Харин Ойрад ястнуудын хувьд газар орон, мал сүргийн эзэн сахиус бол Цагаан өвгөн байх ажээ.



Цагаан өвгөний сан тахилга оршвой. Газар усны сан оршвой хэмээх тод үсгийн судрын хэсэг

3. Бүсгүй хүнээр нэлээд дүрсэлдэг. Энэ нь Этүгэн эхийн шүтлэгийн ул мөр бололтой. Хожуу үеийн ойлголтоор бол шарын шашны буюу цагаан, ногоон дара эхийн бэлгэдэл юм. Говийн ноён хутагт Данзанравжаа дэлхийн энергийн төв хэмээгдэж буй Өмнөговь аймгийн Ханбогд уулын орчимд Дэмчигийн хийдийг байгуулахдаа уг уулын эзэн нь цагаан тэмээ унаж, урд бөхөнд нь аргалийн хурга цухуйсан уут өлгөсөн, ногоон торгон дээлтэй, лимбэ үлээсэн гоо үзэсгэлэнт залуухан сайхан бүсгүй байна” хэмээгээд “Хүн шидтэй төрөх хэрэггүй, энд ирээд л шидийг олох юм байна” гэж айлдсан гэдэг. Тэгээд

Ханбогд уулын эзэн болсон сайхан бүсгүйд зориулан “Үлэмжийн чанар” дууг зохиожээ.

Түүнчлэн Дорнод аймгийн Буйр нуурын хойт этгээд дэх Хүүхдийн овооны эзэн савдаг нь цав цагаан дээл өмссөн, цайвар зүстэй гоо бүсгүй байдаг бөгөөд овооны ойролцоох нэг хадан дээр сууж өтгөс нялхсыг ивээн тэтгэж, үр өгөөжөө хүртээдэг гэж эртнээс бэлгэшээн ирсэн байна. Мөн энэ эзний тухай Н. Жуковская “Буйр нуурын эзэн нь нуурын хойт дэвсгийн хадан дээр суудаг цагаан хувцастай бүсгүй байдаг. Тэр нь загасчдад тусалдаг гэлцэнэ” [Цитата по: Сүхбаатар, 2001: 12] хэмээн тэмдэглэжээ.

4. Зарим уулын эзнийг номч мэргэн хүнээр дүрсэлсэн буй. Тухайлбал, Чингэлтэй уулын эзэн нь олон шавь нартаа ном айлдаж буй өвгөн ламын дүртэй гэх мэт.

5. Мөн цэргийн ноён, баатар жанжны дүртэй байна. Энэ нь ихэвчлэн Монголын хил хязгаарын уул байх бөгөөд дурдвал Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Баяндулаан уулын эзэн нь олон дагуултай, цэргийн догшин ноён гэж сударт өгүүлжээ.


Эдгээрээс үзвэл сангийн судрыг зохиогчид нь тухайн уул усыг шинжин, эзэд савдагийг орчин нөхцөл, ахуй байдалд нь тохируулан сэтгэлдээ ургуулан төсөөлж, уран сайхнаар сэтгэн дүрсэлж ирсэн ажээ.

Уул усны лус савдагийг аргадан тахиж, уншлага ном үйлдэх нь нутаг нутагт ерөнхийдөө ойролцоо байдаг боловч зарим нутагт тэрхүү газрын эзэн савдагт тохируулсан нэлээд өвөрмөц ая дантай байдаг гэдэг.

3. Монгол ахуйг тусгасан нь

Сан тахилгын зан үйл хэдийгээр бөөгийн шүтлэгээс улбаалж, шарын шашны утга санааг агуулсан ч гэлээ монгол ахуйг тусгаснаараа онцлогтой. Дурдвал: эзэд савдагийг морь, тэмээ, бух зэргийг хөлөглөсөн, монгол дээл өмссөн, хурганы уут өлгөсөн зэргээр дүрсэлсэн нь ахуйн буюу иргэний байдалд

идээшүүлсэн хэрэг бөгөөд ард олны таалалд илүү нийцэн, сэтгэлд нь хоногшиход тун дөхөм болсон гэлтэй. Судрууд дахь нутаг орны эзэд савдагийн хөлөг унаа, өмсгөлийн зүйлийг ажиглахад дараах байдалтай байна.



Өмнөговь аймгийн нутаг дахь Ханбогд хайрханы эзний дүрслэл

Нутаг орон	Хөлөг унаа	Өмсгөл
Их Газарын чулуу	Хүрэн тэмээ	
Богд хан уул	Цагаан морь	Цайвар шаргал дээл
Сонгинохайрхан	Хөх бух	Хөх дээл
Чингэлтэй	Улаан ямаа	Цагаан цэнхэр дээл
Баянзүрх	Бар	Торгон хувцас
Өмнөговийн Ханбогд	Цагаан тэмээ	Ногоон торгон дээл
Сүхбаатарын Баяндулаан	Хар хөх морь	
Баянхонгорын Орог нуур	Хар ногоон морь	Ногоон торгон дээл
Хэнтийн Дадал	Хар морь	Хар хувцас
Төв аймгийн Дэлгэрхаан	Хар морь	Хар дээл
Хөгнө хан	Сартай хар морь	

Хасагт хайрхан	Хөх сарлаг	
Ховдын Зэрэгийн гол	Цагаан тэмээ	Ногоон торгон дээл
Дорнодын Дунхан уул	Ухаа хонгор морь	Улбар шар дээл
Сутай уул	Цагаан бух	Цагаан цайвар хувцас
Увсын Хан харгай	Хөх морь	Хөх дээл
Алтан-Овоо	Цагаан морь	Бурханы хувцас
Баянхонгор хайрхан	Цагаан заан	Ногоон торгон хувцас

Г. Газар устай холбогдох хорио цээр

Шарын шашны үзлээр уул усны навдаг, савдаг, шивдагийг аргадан наманчилж, хувь заяагаа даатган залбирснаар тэд баясч, бороо хураа буулган, газар дэлхийн шимийг хүртээдэг гэж үздэг байна. Тийм ч учраас газар усны эздийг амаар дүрслэн домоглож, хөрөглөн буулгаж, амьдчилан хүншүүлсэн үзэл нь улмаар байгаль эхээ хамгаалах хорио цээрийн ёсыг мөн үүсгэжээ. Тэрхүү хорио цээрийн ёс нь өдгөө ч гүн бат оршсоор байгаа билээ.

Аливаа уул усны нэрийг дэргэд нь хамаагүй нэрлэж хэлэх, ойр орчимд нь өтгөн шингэн мөр үзэх, ан гөрөө авлах, гол мөрөн, рашаан булагт улаан цагаан зүйл дусаах, хувцас хунар, нүүр гараа угаахыг цээрлэнэ. Цээртэй холбогдох аман яриа болон бодот явдал нэлээд байдаг. Нэгэн явдлын тухай өгүүлбэл, миний өвөө бага наснаасаа Богдын хүрээний Дашчоймбол дацанд шавилж, буддын гүн ухаанд мэргэшсэн, шаггүй сайн номтой лам хүн байлаа. Өвөөгийнх Ширгүүнэ говиор нутагладаг, ойролцоо нь нэлээд догшин хайрхан, булагтай. Зуны аагим халуун өдөр өвөө маань малын эрэлд явж байгаад тэр булгийн орчимд газар жаахан хонхойлоод морио усалж. Тун удалгүй толгой нь яр шарханд баригдаж, идээ шүүс гараад болохгүй болохоор “булгийн эзэн надаар оролдоод болох юм биш” хэмээгээд дүлцонгийн элс, цац зэрэг зүйл аваад явсан санагддаг

юм. Оройхон лусаа аргадчихлаа гэсээр ирсэн. Нээрээ ганц хоёр хоногийн дараа яр шарх нь эдгэж зүгээр болсон юм.

Энэ мэтчилэн уул усыг шүтэх, сан тахилга үйлдэх зан үйл хийгээд судар номтой холбогдох ёс жаяг маш олон. Үүнээс нэгээхэн хэсгийн талаар өгүүлэхэд ийм буюу.

Дүгнэлт

1. Уул овоо, газар усаа тахин шүтэх монголчуудын ёс заншил, зан үйл эртний бөө мөргөлөөс үүсэлтэй бөгөөд хожим шарын шашны үзэл санаа, утга агуулгаар баяжин хөгжжээ. Чингэхдээ улам уран сайхан дүрслэлтэй, яруу тансаг шүлэглэлтэй судар номын хэлбэрээр ард олны дунд түгэн дэлгэрсэн байна.

2. Байгаль дэлхийгээ шүтэн аж төрсөөр ирсэн нүүдлийн соёл иргэншилтэй монгол түмэн газар усаа эзэн савдагтай хэмээн итгэн биширч, түүнийгээ янз бүрээр амьдчилан дүрсэлж, аргадан тахиж заншжээ. Уул усны эзэн савдагийн дүрслэл нь мөн л нийгмийн хөгжил хувьсал, шашин соёлын түүхэн явцад хувиран өөрчлөгдсөн байдал ажиглагдаж байх ажээ.

3. Сан тахилгын судар хэмжээгээр тийм том биш байх боловч олон талын ач холбогдол бүхий судалгааны чухал хэрэглэгдэхүүн болдог юм. Газар усны нэр, аман яриа, домог хууч болон түүх соёл, үгийн сан, аман зохиолтой холбогдохын зэрэгцээ утга агуулга, үзэл санаа нь түүх төдийгүй байгаль хамгаалалтай холбогдоно. Ялангуяа монгол хэлээр зохиосон сангийн судруудын үг хэллэг үгийн сан судлалын үнэ цэнэтэй, судалгааны чухал ач холбогдол бүхий эх хэрэглэгдэхүүн болно.

Ашигласан ном зохиол

1. Дэмчигмаа О. "Цорж лам Агваандорж бээр зохиосон тэнгэр дэлхий газар орны сан тахилга оршвой" хэмээх судрын тухай // Acta Mongolica / МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. Боть 8 (306). 2008. Х. 251–266.

2. Сүхбаатар О. Монголын тахилгат уул усны судар оршвой. Улаанбаатар, 2001.

3. Сүхбат П. Богд Очирваань Отгонтэнгэр хайрханы түүх шастир, тайлга тахилга, зан үйлийн товчоон оршивой. Улаанбаатар, 2004.
4. Уул овооны сан тахилгын судрууд / Ерөнхий редактор Д. Мөнхсайхан. Улаанбаатар, 2004.
5. Хүрэлбаатар Л. Судар шастирын билиг. Улаанбаатар, 2002.
6. Rachewiltz Igor De. Index to the Secret History of the Mongols. Bloomington: Indiana University, 1972.
7. Sa chen ri po'i bsangs mchod 'bul tshul mdor bsdus pa las bzhi lhun 'grub bzhugs so (Их Газар Уулын тахил ариулал өргөх ёсны товч хураангуй Дөрвөн үйл аяндаа бүтэхүй оршвой). 3 хуудастай. Хувийн цуглуулгад.
8. Ha sag thu ha ri han la bsangs mchod bkra shis sman ljong zhes bya ba bzhugs so (Хасагт хайрханд сан тахил өргөх өлзийт эмийн шилтгээн хэмээх оршвой). 4 хуудастай. Хувийн цуглуулгад.

References

1. Demchigmaa O. "Tsorzh lam Agvaandorzh beer zokhioson tenger delkhii gazar орны сан takhilga оршвои" khemeekh sudryn tukhai // Acta Mongolica / MUIS-iin Erdem шинжилгэний бичиг. Bot' 8 (306). 2008. Kh. 251–266.
2. Сыкхбаатар О. Mongolyn takhilgat uul usny sudar оршвои. Ulaanbaatar, 2001.
3. Sykhbat P. Bogd Ochirvaan' Otgontenger khairkhany tyukh shastir, тайлга takhilga, зан үйлийн товчоон оршвои. Ulaanbaatar, 2004.
4. Уул овооны сан тахилгын судрууд / Ерөнхий редактор Д. Мөнхсайхан. Улаанбаатар, 2004.
5. Хүрэлбаатар Л. Судар шастирын билэг. Улаанбаатар, 2002.
6. Rachewiltz Igor De. Index to the Secret History of the Mongols. Bloomington: Indiana University, 1972.
7. Sa chen ri po'i bsangs mchod 'bul tshul mdor bsdus pa las bzhi lhun 'grub bzhugs so (Их Газар Уулын тахил ариулал өргөх ёсны товч хураангуй Дөрвөн үйл аяндаа бүтэхүй оршвои). 3 хуудастай. Хувийн цуглуулгад.
8. Ha sag thu ha ri han la bsangs mchod bkra shis sman ljong zhes bya ba bzhugs so (Хасагт хайрханд сан тахил өргөх өлзийт эмийн шилтгээн хэмээх оршвои). 4 хуудастай. Хувийн цуглуулгад.

СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ

АЮШЕЕВА Марина Васильевна – кандидат исторических наук, научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: ayagma@yandex.ru

БУРАЕВА Светлана Валерьевна – доктор исторических наук, ведущий научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: ladys@inbox.ru

ДАШИБАЛОВА Дарима Владимировна – кандидат филологических наук, старший научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: dardash3@gmail.com

ДЭМЧИГМАА Оуюнханд – PhD, доцент, кафедра монгольского языка и лингвистики Монгольского государственного университета. E-mail: odemchigmaa2000@gmail.com

ЖАБОН Юмжана Жалсановна – кандидат исторических наук, старший научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: yumzhan@mail.ru

КАМАЛОВ Аблет Каюмович – профессор Университета «Туран», Алматы, Казахстан. E-mail: a.kamalov@turand.edu.kz

ЛЕПЕХОВ Сергей Юрьевич - доктор философских наук, главный научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: lepekhov@yandex.ru

МИЯГШЕВА Суржана Борисовна – кандидат исторических наук, научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: surjana@yandex.ru

НАРАНЗАНДАН – аспирант Института литературы и языка национальных меньшинств при Центральном университете Китая (Пекин). E-mail: naranzandan@hotmail.com

РИНЧИНОВ Олег Сергеевич – кандидат физико-математических наук, координатор Центра восточных рукописей и ксилографов Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: orinch2@mail.ru

ХИТОШИ КУРИБАЯШИ – почетный профессор Университета Тохоку (Япония). E-mail: hkuri@gerel.net

ЦЭЦЭГМАА Жамбалын – доктор наук (Sc.D), проректор университета «Их Засаг». E-mail: tuul.iziu@gmail.com

ЦЫПИЛОВА Снежана Сергеевна – кандидат исторических наук, младший научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: ai_qing@mail.ru

ЦЫРЕНОВ Чингис Цыбикдоржиевич – кандидат исторических наук, научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: chts17@mail.ru

HONG JUN (UUKHAN JAMIYAN) – PhD, Институт философии и религиоведения, Монгольский государственный университет. E-mail: Jamiyan108@yahoo.com

Содержание

РЕЛИГИЯ, ЭТНОГРАФИЯ И КУЛЬТУРА

<i>Лепехов С. Ю.</i> ПРЕДСТАВЛЕНИЯ О ТАТХАТЕ И ШУНЬЯТЕ В «РАТНА-ГУНА-САМЧАЯ-ГАТХЕ».....	3
<i>Hong Jun.</i> АНАЛИЗ КИТАЙСКОЙ, ТИБЕТСКОЙ И МОНГОЛЬСКОЙ ВЕРСИЙ АВАТАМСАКА-СУТРЫ.....	32
<i>Жабон Ю. Ж.</i> КРАТКОЕ ОПИСАНИЕ ЖИЗНИ И ТВОРЧЕСТВА ДАМЦИК ДОРДЖЕ (1781–1855).....	44
<i>Дэмчигмаа О.</i> УУЛ УСАА ДЭЭДЛЭН ШҮТЭХ МОНГОЛ ЁС ХИЙГЭЭД САН ТАХИЛГЫН СУДАР.....	56
<i>Миягашева С. Б.</i> РОДОСЛОВНЫЕ, ЛЕГЕНДЫ И ПРЕДАНИЯ ХОРДУТСКИХ ШАМАНОВ.....	68

ЦИФРОВЫЕ ТЕХНОЛОГИИ В ГУМАНИТАРНЫХ ИССЛЕДОВАНИЯХ

<i>Kuribayashi Hitoshi.</i> ON THE DEVELOPMENT AND UTILIZATION OF WEB-DICTIONARY OF MONGOLIAN TRADITIONAL DICTIONARIES.....	91
<i>Ринчинов О. С.</i> СТРУКТУРНАЯ РАЗМЕТКА БУРЯТСКИХ СТАРОПИСЬМЕННЫХ СОЧИНЕНИЙ ДЛЯ ДИАХРОНИЧЕСКОГО КОРПУСА БУРЯТСКОГО ЯЗЫКА	106

ИСТОРИЯ, ИСТОЧНИКОВЕДЕНИЕ, АРХИВОВЕДЕНИЕ

<i>Камалов А. К.</i> «УЙГУРСКИЙ ПУТЬ» – СЕВЕРНАЯ ВЕТВЬ ВЕЛИКОГО ШЕЛКОВОГО ПУТИ (ПРЕДВАРИТЕЛЬНЫЙ АНАЛИЗ).....	118
<i>Цыренов Ч. Ц.</i> ВНЕШНЯЯ ТОРГОВАЯ ПОЛИТИКА МАНЬЧЖУРСКИХ МОНАРХОВ РАННЕГО ПЕРИОДА ДИНАСТИИ ЦИН (ПО МАТЕРИАЛАМ ХРОНИКИ «ДАЙ ЦИН ТАЙЦЗУ ШИЛУ»).....	132
<i>Наранзандан.</i> ИСТОРИИ ИЗ ЖИЗНИ ШЭНЭХЭНСКИХ БУРЯТ.....	145
<i>Цэцэгмаа Ж.</i> ЖАМСРАНГИЙН ЦЭВЭЭНИЙ “УЛСЫН ЭРХ” ЗОХИОЛЫН ТУХАЙД.....	165
<i>Аюшеева М. В.</i> ПУТЕВЫЕ ЗАМЕТКИ СОЛО ВАНДАНОВА.....	173
<i>Бураева С. В.</i> ЛЕТОПИСЬ НАУЧНЫХ БУДНЕЙ: ХАРАКТЕРИСТИКА ФОТОМАТЕРИАЛОВ 1920–1960-Х ГГ. ИЗ АРХИВНОГО ФОНДА ЦВРК.....	187
<i>Дашибалова Д. В.</i> О РАБОТАХ Н. П. ШАСТИНОЙ В АРХИВНОМ И БИБЛИОТЕЧНОМ ФОНДАХ ЦВРК ИМБТ СО РАН.....	197
<i>Цытилова С. С.</i> ДНЕВНИКИ В. Ц. НАЙДАКОВА В ФОНДАХ ЦЕНТРА ВОСТОЧНЫХ РУКОПИСЕЙ И КСИЛОГРАФОВ ИМБТ СО РАН.....	206
СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ.....	219